


БАТЛАВ.

ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ ДЭД БҮТЭЦ ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ



Ж.ГАНБААТАР

**ХИЛИЙН “ДАЯН” БООМТЫН ӨРГӨТГӨЛ ШИНЭЧЛЭЛИЙН
АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР**

2024 оны 04-р сарын 26-ны өдөр

Дугаар №...

Улаанбаатар хот

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл, зорилго	<p>Боловсруулах үндэслэл:</p> <ul style="list-style-type: none">- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого /УИХ-ын 2020 оны 52-р тогтоол/- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр /УИХ-ын 2020 оны 24-р тогтоол/ <p>Боловсруулах зорилго:</p> <p>Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Шинэ сэргэлтийн бодлого “Боомтын сэргэлт”-ийн хүрээнд хилийн хяналт шалгалтыг боловсронгуй болгох, нэвтрэх чадварыг сайжруулах, зорчигчдын ая тухтай орчныг бий болгох, хилийн ажилчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах.</p>
2	Төслийн захиалагч	<ul style="list-style-type: none">- Монгол Улсын Сангийн Яам, “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төсөл.
3	Байршил	<ul style="list-style-type: none">- Баян-Өлгий аймаг, Сагсай сум
4	Зураг төсөл боловсруулах үе шат	<ul style="list-style-type: none">- Эх загвар зураг- Ажлын зураг төсөл
5	Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<ul style="list-style-type: none">- Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, норм ба дүрэм, журам, стандартууд- Хилийн хяналтын байгууллагуудын санал, зөвлөмж- Олон улсад ашиглаж байгаа шинэ, дэвшилтэт техник, технологи
6	Баримт бичгийн бүрдэл /Масштабыг зөвшилцөх/	<p>Бичиглэлийн иж бүрдэл:</p> <ul style="list-style-type: none">- Зураг төслийн дэвсгэр зургийн WGS-84, UTM буюу солбилцолын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэнэ. Батлагдсан иж бүрэн ажлын зураг, тайлбар бичиг, Техникийн шаардлага, инженер геологийн дүгнэлт, геодезийн ажлын тайлан, нэгдсэн төсөв болон бусад холбогдох бичиг баримтыг захиалагчийн шаардлагын дагуу хүлээлгэн өгөх. Ерөнхий харагдах байдал, /3D/ видео шторк /захиалагчтай зөвшилцөж одоо, хуучинг харьцуулсан, тоон мэдээлэлтэй/

ОДООГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА, ДҮГНЭЛТ:

1 . Судалгааны зураглал:

- Байршлын схем тойм зураг
- Орчны тойм
- Дэвсгэр зураг/орто фото зураглал хийх/

2 . Төлөвлөлтийн бүсэд хийгдсэн судалгааны материалууд:

- Орчны геодезийн нарийвчилсан судалгаа.
- Инженерийн дэд бүтцийн судалгаа, трассын зураглал.
- Барилга байгууламж, зам талбайн хяналтын байгууллагын ашиглалтын дүгнэлт
- Бусад шаардлагатай судалгаанууд.

ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗУРАГЛАЛ:

- Захиалагч, хилийн хяналтын болон бусад байгууллагуудтай зөвшилцөж, норм дүрэм, стандартын дагуу хийх.
- Боомт болон боомтын бүсэд төлөвлөгдсөн, төлөвлөж буй бусад төслүүдтэй уялдуулах.
- Хөрш орны боомт болон Монгол улсын авто замын сүлжээтэй уялдуулан төлөвлөх /Захиалагчтай зөвшилцөх/

Ерөнхий төлөвлөлт:

- Ерөнхий төлөвлөлт /Батлагдах хуудас/
- Төлөвлөлтийн бүсчлэл
- Барилга байгууламж, авто зам талбай, инженерийн шугам сүлжээний нэгдсэн төлөвлөлт, өндөржилт
- Инженерийн шугам сүлжээний төлөвлөлт
- Гэрэлтүүлгийн төлөвлөлт
- Камержуулалтын төлөвлөлт
- Барилгажилтын зай хэмжээ
- Барилга, Байгууламжийн өндөржилт
- Тохжилт ногоон байгууламжийн зураг, зай хэмжээ, тоо хэмжээ
- Архитектур орон зайн төлөвлөлт, барилгажилт
- Үерийн хамгаалалтын далан суваг
- Галын хамгаалалтын зурвас
- Хөдөлгөөн зохион байгуулалтын схем
- Гамшгийн менежмент схем
- Хог хаягдлын менежмент схем
- Боомтын орчны экологи, хот байгуулалтын үнэлгээ
- Барилга угсралтын ажлын үед ашиглах түр боомтын төлөвлөлт, хөдөлгөөн зохион байгуулалт
- Орчин үеийн дэвшилтэт технологи, шинэлэг шийдэл тусгах /захиалагчтай зөвшилцөх/

Барилга, архитектурын ажлын зураг:

- Захиалагч, хилийн хяналт, ашиглагч болон бусад байгууллагуудтай зөвшилцөж, баталгаажуулан боловсруулах.
- Засварлах барилгын ажлын зураг, тоо хэмжээг гаргаж, төсөв боловсруулах
- Засварлах, Буулгах болон шилжүүлэх барилга байгууламж, зам талбай, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн өмчлөгч байгууллагыг тодорхойлж холбогдох тушаал шийдвэрийг үндэслэх
- Буулгах болон шилжүүлэх барилга байгууламж, зам талбай, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ажлын зураг төсөв боловсруулах

Авто зам, талбайн ажлын зураг:


- Тайлбар бичиг /хөдөлгөөний эрчмийн тооцоог гаргаж хучилтын тооцоог хийж тусгах/
- Техникийн шаардлага
- Инженер геологийн дүгнэлт
- Геодезийн ажлын судалгаа, тайлан

		<ul style="list-style-type: none"> - Түгээмэл тархацтай ашигт малтмалын судалгаа/<i>карьер</i>ын судалгаа/ - Дэвсгэр зураг - Авто зам талбайн зай хэмжээний зураг - Авто замын нэг маягийн хөндлөн огтлол /бүх онцлог цэгүүд дээр харуулах/ - Авто замын дагуу болон хөндлөн огтлол /төлөвлөж буй, одоо байгаа барилга байгууламжийг байршуулах/-ын зураг - Авто зам талбайн өндөржилт /барилга байгууламж, ИШС, тохижилттой уялдуулсан байх/-ийн зураг - Авто зам талбайн Картограмм - Авто зам талбайн ус зайлуулах систем - Хөдөлгөөн зохион байгуулалт - Барилгын ажлын үед түр боомтын үйл ажиллагаатай уялдуулан түр зам төлөвлөх <p><u>Инженер шугам сүлжээний ажлын зураг:</u></p> <ul style="list-style-type: none"> - Инженерийн шугам сүлжээний нэгдсэн төлөвлөлт - Инженерийн бэлтгэл арга хэмжээ - Үерийн хамгаалах байгууламж - Дулаан хангамж - Усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж - Ундны усны цэвэршүүлэх байгууламж - Цахилгаан хангамж - Гадна гэрэлтүүлэг - Мэдээлэл, холбоо дохиолол, камержуулалтын шугам сүлжээ - Орчин үеийн дэвшилтэт технологи, шинэлэг шийдэл тусгах /захиалагчтай зөвшилцөх/
7	Зураг төсөлд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Холбогдох байгууллагуудын өгсөн санал зөвлөмжүүдийг баталгаажуулсан байх - Эрх бүхий байгууллага, албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдэг бүрэн дарж, Магадлалаар баталгаажуулсан байх; - Түүх соёлын үнэт өв дурсгал замын трасс-д орсон тохиолдолд холбогдох байгууллагуудтай зөвшилцөн хамгаалах болон нүүлгэн шилжүүлэх ажлыг эцэслэн шийдвэрлэсэн байна. - Монгол улсын байгаль, цаг уурын онцлог, тооцооны үндсэн өгөгдөл, хууль тогтоомж, норм дүрэм стандартыг баримтлан ажлын зураг, төсвийг боловсруулах. - Төсвийг тооцооны /ESTIMATOR-PRO/ программаар гүйцэтгэх.
8	Төлөвлөлтийн үндсэн нөхцөл	<p><u>Архитектур орон зайн төлөвлөлт:</u></p> <ul style="list-style-type: none"> - Захиалагч, хилийн хяналтын болон бусад байгууллагуудтай зөвшилцөж, норм дүрэм, стандартын дагуу хийх. - Барилга байгууламжуудыг эрчим хүч хэмнэх, урсгал зардал бага байх шийдлээр төлөвлөх - Барилга байгууламжуудын хийцлэл, материалыг удаан эдэлгээтэй, бат бөх чанартай, үзэмжтэй байхаар төлөвлөх - Барилга байгууламжуудын хэлбэр загвар, өнгөний сонголтыг захиалагчтай зөвшилцөх - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажиллах, зорчих орчин нөхцөлийг бүрдүүлсэн стандарт шаардлагыг хангасан байх - Хилийн хаалганы дизайн загвар, байрлалыг захиалагчтай зөвшилцөж төлөвлөх - Зарим барилгуудад интерьер зураг боловсруулж, ажлын зураг төсөлд тусгах /захиалагчтай зөвшилцөх/ - Барилга тус бүрд технологийн байгуулалт, тавилга, тоног төхөөрөмжийг тусгах /захиалагчтай зөвшилцөх/ - Барилгын дулаалгын хийцлэл, гадна фасадад уламжлалт сэндвич, хөөсөнцөр материал ашиглахгүй байх - Барилгуудын дотоод зохион байгуулалт тоноглол зэргийг хилийн хяналтын байгууллагуудтай зөвшилцөж төлөвлөх

9	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	<p><u>Инженерийн шугам сүлжээний төлөвлөлт:</u></p> <ul style="list-style-type: none"> - Инженерийн шугам сүлжээг аль болох зам талбайд бага өртөхөөр тооцож төлөвлөх - Инженерийн шугам сүлжээний материалыг стандарт шаардлага хангасан удаан эдэлгээтэй байх - Одоо байгаа хуучин барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээний оролт гаралт тааруулах - Инженерийн бэлтгэл ажлыг төлөвлөхдөө нарийвчилсан судалгааг үндэслэн тооцоолох <p><u>Хог хаягдал:</u></p> <ul style="list-style-type: none"> - Боомтын хог хаягдлыг цуглуулах, ангилах, тээвэрлэх, зайлуулах, дахин ашиглах, устгах, тусгай цэг байгуулах менежментийн төлөвлөлтийг боловсруулах
10	Зөвшөөрөлцөх байгууллага	<ul style="list-style-type: none"> - Хөгжлийн хөтөч - дэд бүтэц төсөл /төсөл боловсруулах үе шат бүрд болон магадлалд орохоос өмнө зөвшөөрөлцсөн байх/ - Эдийн засгийн хөгжлийн яам, Боомтын захиргаа ,Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Гадаадын иргэн харьяатын газар, Онцгой байдлын ерөнхий газар - Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-д заасан байгууллагууд

ХЯНАСАН:


Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц төслийн менежер



Г Дэлгэр


БОЛОВСРУУЛСАН:

Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц төслийн ИТА-ны дарга




А.Ермек

Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц төслийн Ахлах архитектор




Д.Батбаяр

Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц төслийн Холбооны инженер



Г.Чинзориг

Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц төслийн ХАБЭА инженер



Б.Зөвцэцэг


Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц төслийн Авто замын инженер



Б.Мандуул

БАТЛАВ.

“ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ-ДЭД БҮТЭЦ”
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ



/Ж.ГАНБААТАР/

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН САГСАЙ СУМ, ХИЛИЙН ДАЯН БООМТЫН
ӨРГӨТГӨЛ ШИНЭЧЛЭЛИЙН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 он 05 сар 01 өдөр

Дугаар

Улаанбаатар хот

1. Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах үндэслэл, зорилго	<p>Үндэслэл:</p> <ul style="list-style-type: none">- МУ-ын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.18- “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого /УИХ-ын 2020 оны 52-р тогтоол/- “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай”-ын 2021 оны 106 дугаар тогтоол- Хилийн боомтын Үндэсний зөвлөлийн 2021 оны 6 дугаар сарын 17-ны №2 тогтоол “ <p>Зорилго:</p> <p>Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Шинэ сэргэлтийн бодлого, Боомтын сэргэлтийн хүрээнд хилийн хяналт шалгалтыг боловсронгуй болгох, нэвтрэх чадварыг сайжруулах, зорчигчдын ая тухтай орчинг бий болгох, хилийн хяналтын албан хаагчдын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах</p>
2. Захиалагч байгууллага	- Монгол улсын Сангийн яам, “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төсөл
3. Зориулалт	- Боомтын зорчигч болон ачаа тээврийн шалган нэвтрүүлэх барилга, байгууламж, авто зам талбай, инженерийн дэд бүтэц бүхий цогцолбор /цаашид “Хилийн Даян боомтын цогцолбор” гэх/ барих
4. Байршил	- Баян-Өлгий аймаг, Сагсай сум, хилийн Даян боомт
5. Хүчин чадал	- Судалгааны үндсэн дээр тооцоолно.
6. Барилга байгууламжийн бүрэлдэхүүн	- Боомтын барилга, байгууламж, авто зам, талбай, инженерийн дэд бүтэц бүхий цогцолбор байна.
7. ТЭЗҮ боловсруулах хугацаа	- Гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгэнэ.

<p>8. Техник эдийн засгийн үндэслэлийн бүрдэл</p>	<p>ТЭЗҮ боловсруулахдаа төслийг хэрэгжүүлэх хөгжлийн хэрэгцээ, нийгэм, эдийн засгийн үндэслэл, хууль эрх зүйн орчин, зах зээл, хүний нөөцийн чадавх, дэд бүтцийн хүчин чадал, хангамж зэргийг нарийвчлан судалж, техник, технологийн шийдэл, хүрээлэн буй орчинд нөлөөлөх байдал, байр талбайн хэрэгцээнд тулгуурлан төслийн эдийн засгийн үзүүлэлтүүдийг тооцоолж, шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ, ажиллах хүч, түүхий эд, зардлын хэмжээ, олох ашиг, санхүү үр ашгийн тооцоо, нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ, эдийн засгийн шинжилгээ, байгаль орчны төлөв байдлын шинжилгээ, инженер геологийн судалгаа зэрэг нарийвчилсан судалгаануудыг хийж төслийн хэрэгжүүлэх хувилбаруудыг тодорхойлно.</p> <p>Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> - Боомтын одоогийн барилга, байгууламж, авто зам, талбай, дэд бүтцийн байршил, хүчин чадал, эх үүсвэр болон хэрэглэгчдийн хэрэглээг судлан тодотгох, тодорхойлох - Боомтын одоогийн болон ирээдүйн өсөлтийн судалгаа, тооцоо, шинжилгээний ажлуудыг хийж төлөв байдлыг тодорхойлох, саналаа боловсруулах - Талбай чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийг судлах, тооцох - Бодлого, хууль, эрх зүйн орчинг судлах, тодорхойлох - Инженер геологийн судалгаа, дүгнэлт болон байр зүйн зургийг гаргана. Барилга, байгууламжийн төвөгшлийг тодорхойлно. - Байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгах, - Ундны болон ахуйн усны эх үүсвэрийн нөөцийг нарийвчлан тогтоож, тодорхой болгох, - Боомтын цахилгаан хангамжийн төлөвлөсөн эх үүсвэрийг цаашид дотоодын болон бусад эх үүсвэрээс хангах боломжит хувилбарийг судалж, саналыг тусгах, - Эдийн засгийн шинжилгээ хийх (SWOT, PEST гэх мэт) - Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж, аялал жуулчлалын бүтээгдэхүүний судалгаа, нийгэм эдийн засгийн ач холбогдлыг тодорхойлох. <p>ТЭЗҮ-ийн тайланд дараах утгууд тусгагдсан байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Судалгаа, үнэлгээ, дүн шинжилгээ
---	--

	<ul style="list-style-type: none"> - Байгалийн нөхцөл, нөөц - Эдийн засаг, нийгэм - Хүн ам, хөдөлмөрийн нөөц - Нутаг дэвсгэрийн ашиглалт /газрын нэгдмэл сангийн ангиллаар/ - Салбарын хөгжил /дэд бүтэц, аялал зуучлал, шинжлэх ухаан, аж үйлдвэр, соёл, хөдөө аж ахуй/ 2. Төлөвлөлтийн шийдэл, тогтвортой хөгжлийн бодлого, <ul style="list-style-type: none"> - Байгалийн нөхцөл, нөөцийн зүй зохистой ашиглалт - Байгаль орчны хамгаалал, нөхөн сэргээлт, хүрээлэн буй орчны хамгаалал, ногоон хөгжил - Эдийн засгийн хөгжил, хөгжлийн тэргүүлэх чиглэл 3. Дэд бүтэц <ul style="list-style-type: none"> - Зам, тээвэр ложистик - Эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч - Холбоо, мэдээлэл - Ус, хангамж, ариутгах татуурга - Бусад 4. Нутаг дэвсгэрийн зохион байгуулалт 5. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчны бүрдүүлэлт 6. Төсөл хэрэгжилтийн менежментийн төлөвлөгөө 7. Хөрөнгө оруулалтын тооцоо, үр ашиг, хэрэгжүүлэх үйл ажиллагааны зөвлөмж 8. Эрсдэлийн үнэлгээ 9. Хувилбарт суурилсан дүгнэлт ба зөвлөгөө 10. Зайлшгүй гүйцэтгэх шаардлагатай ажил үйлчилгээ болон төслийн схем, зураг боловсруулалт
<p>9. ТЭЗҮ боловсруулах байгууллага</p>	<ul style="list-style-type: none"> - Барилга, байгууламжийн ТЭЗҮ боловсруулах тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий хуулийн этгээд байна.
<p>10. Онцгой нөхцөл</p>	<ul style="list-style-type: none"> - Байгаль цаг уур, хөрсний бүтэц, газар хөдлөлийн тэсвэрлэлтийн зэрэгтэй уялдуулан төлөвлөх - Төлөвлөлтийг хийхдээ эдийн засгийн хэмнэлттэй, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэхээр төлөвлөх; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төлөвлөлтийг заавал тусгах - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, тав тухтай орчинг бүрдүүлэхээр төлөвлөх - Барилга, байгууламж, авто зам, талбайн хийц, ашиглах түүхий эд, материал, орд газар, бүтээцийн талаар судлаж тусгах


	<ul style="list-style-type: none"> - Хамгаалалтын зурвасыг хангуулах, өөрийн эзэмшлийн газарт шаардагдах газар чөлөөлөлтийн зардлыг төсөвт тусгах; - Боомтын хуучин барилгуудын болон ахуйн хог хаягдлын талаар судлах, дэвшилтэд аргыг нэвтрүүлэхээр тусгах - Барилгын талбай чөлөөлөх, зарим барилга байгууламж зөөх, сэргээх, боомтыг түр горимд шилжүүлэх эсэх талаар судлаж зөвлөмж гаргах, өртөг тооцоолох - Онцгой болон Галын аюулгүй байдал, агааржуулалтыг бүрэн хангахаар төлөвлөх - Монгол улсад мөрдөж байгаа хууль, тогтоол, дүрэм, журам, стандарт, нормыг мөрдөж, тусгаж ажиллах
11. Зөвшөөрөлцөх байгууллага	<ul style="list-style-type: none"> - Эдийн засгийн хөгжлийн яам болон бусад холбогдох яам - Сангийн яам, "Хөгжлийн хөтөч-дэд бүтэц" төсөл - Боомтын захиргаа - Гаалийн Ерөнхий газар - Хил хамгаалах Ерөнхий газар - Инженерийн хангамжийн байгууллагууд - Онцгой байдлын ерөнхий газар /галын аюулгүй байдлаар/ - Баян-Өлгий аймгийн ЗДТГ
12. Баталгаажуулалт	<ul style="list-style-type: none"> - Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан, Ерөнхий дүгнэлт, Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын яамаар; - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм болон бусад хууль, журмын дагуу батлуулах
13. Хүлээлцэх тайлан	<ul style="list-style-type: none"> - Техник эдийн засгийн үндэслэлийн тайлан /иж бүрэн баримт бичиг/ 4 хувь болон PDF файлаар хүлээлгэж өгнө. Үүнд 1 эх хувь, 3% нь тод, гаргацтай, эх хувьтай ижил төвшинд байхаар/. - ТЭЗҮ-гийн төвшинд зурж боловсруулсан нэмэлт мэдээлэл, зураг схемүүдийг тайлангийн хавсралтад оруулна.

Хянасан:


Төслийн менежер

ИТА-ны дарга


Боловсруулсан: Эдийн засагч, судлаач



/Г.Дэлгэр/



/А.Ермек/



/Б.Билгүүн/

БАТЛАВ.
"ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ ДЭД БҮТЭЦ"
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ



Ж.ГАНБААТАР

**МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ДАЯН БООМТЫН БАЙГАЛЬ
ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР**

Үндэслэл:

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн дагуу дараах Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийнэ. Үүнд:

1. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ
2. Байгаль орчны нөлөөллийн Ерөнхий үнэлгээ, дүгнэлт
3. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ

Зорилго:

1. Хилийн Даян боомтын барилга, байгууламжийг өргөтгөн шинэчлэхээс өмнө тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлыг судлан тогтоож, цаашид төслийг боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлох;

2. Төслийн ажлын зураг, төсөл боловсруулалтын үе шатанд болон түүний дараа тухайн төслийг хэрэгжүүлснээр хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийн хэмжээ, үр дагавар, хамрах хүрээ, учруулах хохирлын хэмжээг тогтоож, түүнийг багасгах, арилгах арга хэмжээ, технологийн шийдэл, төслийн хэрэгжүүлэх хамгийн оновчтой хувилбарыг тогтооход оршино.

Хамрах хүрээ:

1. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг хийхдээ дараах чиглэлээр судалгаа шинжилгээ хийж тайлан боловсруулна. Үүнд:

- Физик газарзүй, ландшафт;
- Геологийн тогтоц;
- Геоморфологи;
- Гидрогеологийн нөхцөл;
- Газар доорх усны нөөц, горим, чанар;
- Цаг уур, уур амьсгал;
- Агаарын чанар;
- Хөрсөн бүрхэвч;
- Ургамалан нөмрөг;
- Амьтны аймаг;
- Байгаль түүх, соёлын дурсгалт газар;
- Тусгай хамгаалалттай газар нутаг;
- Газар зохион байгуулалт;
- Нийгэм, эдийн засаг;
- Болзошгүй нөлөөлөл зэрэг бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй болно.

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллага, тухайн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн, судлаачдын оролцоотойгоор, шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгааны арга зүйг ашиглан судалгаа, шинжилгээг хийнэ.

2. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг үндэслэн Байгаль орчны нөлөөллийн Ерөнхий үнэлгээг хийлгэж, дүгнэлт гаргуулах бөгөөд үүнийг үндэслэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийнэ.

3. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн 4, 6, 7, 8, 9, 11 дүгээр зүйл заасныг баримтлан байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийх;
- Нарийвчилсан үнэлгээг ерөнхий үнэлгээний дүгнэлт болон Монгол улсын хууль тогтоомжоор батлагдсан журам, аргачлалын дагуу гүйцэтгэнэ;
- Төслийг хэрэгжүүлэх явцад технологийн оновчтой хувилбарын сонгох, уг төслөөс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг нарийвчилсан үнэлгээний үндсэн дээр тодорхойлох, тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчны суурь үнэлгээг тодруулах;
- Барилга байгууламжийг гүйцэтгэх ажил болон төсөл хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй ослын үнэлгээ хийлгэх, барилгын техник хэрэгслийг байршуулах түр талбай, ажилчдын байр, ашиглах техник хэрэгслээс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлж, түүнийг багасгах арга хэмжээ, зөвлөмжийг боловсруулах;
- Барилга байгууламжийн ажилд шаардагдах түүхий эд /элс, хайрга, дайрга г.м/, шатах тослох материалын нийлүүлэлт, хадгалалт, ашиглалтын талаар нарийвчлан судалгаа гаргаж, эх үүсвэр бүрийг нарийвчлан тогтоох;
- Барилгын ажилд ашиглах элс, хайрга, дайрга болон бусад түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх төслийг боловсруулж хэрэгжүүлэх, тусгай зөвшөөрлөөр олгогдсон этгээдээс авч ашиглах тохиолдолд элс, хайрга, дайрга нийлүүлэх гэрээг урьдчилан байгуулж, тээвэрлэлтийн үеийн тоосжилт, аюулгүй ажиллагааны зөвлөмжийг боловсруулах;
- Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг боловсруулж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тооцож төлөвлөх;
- Барилгын ажлын явцад баримтлах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны заавар, ажиллагсдын эрүүл мэнд, ажлын байрны эрүүл ахуйн талаар зөвлөмж, дүгнэлт боловсруулах;
- Төслийг хэрэгжүүлэх шатанд туслах замыг оновчтойгоор шийдвэрлэх, туслах замаас болон түр зам, барилгын ажлын явцад үүсэх тоосжилтыг багасгах арга замыг төлөвлөх;
- Барилга байгууламж баригдах орчмын гол, сайрын ус хурах талбай, урт, хамгийн их бага дундаж өргөнийг нарийвчлан тогтоох, үерийн усны хамгийн их өнгөрөлтийг тооцож, түүнтэй уялдуулан үерийн ус зайлуулах сувгийг оновчтойгоор байгуулах зөвлөмж боловсруулах, барилгын ажилд шаардагдах усны хэрэглээ, эх үүсвэрийг нарийвчлан тогтоох;
- Байгаль орчны сайдын 2006 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 195 дугаар тушаалын хавсралт “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний шинжилгээ хийх журам” -ыг мөрдлөг болгоно;
- Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээнд заагдсан нарийвчилсан үнэлгээ хийх чиглэл, хуваарийг баримтална.
- Барилга байгууламжийн ашиглалтын дараах нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг тусгах;
- Шаардлагатай тохиолдолд сонгосон газарт ажлын зураг авалт хийж, бодит байдалд нийцсэн тооцоо судалгааг хийх;
- Тусгай ангиллын хог хаягдлыг үйл ажиллагаа эрхэлж буй зарим томоохон аж ахуйн нэгж байгууллагуудын холбогдох мэргэжилтнүүдтэй хамтарч ажиллах.

Ач холбогдол:

Төсөл хэрэгжүүлэхээс өмнө Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийснээр төслийн төлөвлөлтийг байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө багатайгаар төлөвлөх, хэрэгжүүлэх явцад гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн улмаас орчны хувьсал өөрчлөлт, бохирдол доройтлыг бодитойгоор тогтоох, шаардлагатай арга хэмжээг цаг алдахгүй авах, төслийн нөлөөлөлд өртөгсөд, сонирхогч талуудыг бодитой мэдээллээр хангах.

Ажиллах хүрээ:

- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, орон нутгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар;
- Хөгжлийн Хөтөч -Дэд Бүтэц төсөл;
- Хилийн хяналтын байгууллагууд;

Ажиллах хугацаа:

Тус гэрээт ажлыг гэрээ байгуулагдсан өдрөөс хойш хуанлийн 75 хоногт багтаан (БОАЖЯ-аар батлуулах хугацаа орсон) хийж гүйцэтгэнэ. Тендерт оролцогч ерөнхий гүйцэтгэгч компанийн ажлын төлөвлөгөөтэй уялдуулан нэгдсэн ажлын график төлөвлөгөөг ирүүлнэ.

Тайлан:


Дараах тайлангуудыг шаардлагад нийцүүлэн боловсруулж захиалагч байгууллагад танилцуулан, холбогдох байгууллагын саналыг авч баталгаажуулан төлөвлөгөөт хугацаанд хүлээлгэн өгнө. Үүнд:

1. Эхлэлийн тайлан;
2. Явцын тайлан;
3. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан;
4. Байгаль орны нөлөөллийн Ерөнхий үнэлгээ, дүгнэлт;
5. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамт;
6. Гэрээт ажлын дагуу гүйцэтгэсэн үнэлгээний тайланг файл болон цаасан хэлбэрээр тус бүр 4% /хувь/ хийгдсэн байх ба холбогдох зураг, схемийг хавсаргаж бэлтгэсэн байна.


Гарах үр дүн:

1. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан;
2. Байгаль орчны нөлөөллийн Ерөнхий үнэлгээ, дүгнэлт
3. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамт;
4. Эцсийн тайлан.

Хянасан: АТСА-ны дарга

 /Б.Мягмаржав/

Боловсруулсан: Эдийн засагч, судлаач

 /Б.Билгүүн/